



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 19-ны өдөр

Дугаар 1/60

Эрхэмт

Урьдчилан сэргийлэх үзлэгт
хамруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 43.2,10 дахь заалт, 8.1.21 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын А/72 дугаар тушаал "Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/420 дугаар "Хүн амын нас, хүйс, эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулах тухай" тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих хүн амын тоог хоёрдугаар, эрт илрүүлэг үзлэгийн сарын мэдээний хүснэгтийг гуравдугаар, шинээр оношлогдсон өвчлөлийн эмчилгээ, хяналтын талаарх мэдээллийн хүснэгтийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрт илрүүлэг үзлэгийг үр дүнтэй зохион байгуулж, сар бүр мэдээллэх, илрүүлэг үзлэгээр шинээр оношлогдсон өвчлөлийн эмчилгээ, хяналтын талаарх мэдээллийг хавсралт 4-ийн дагуу гаргаж, сарын мэдээний хамт Эрүүл мэндийн газарт ирүүлж байхыг "Медипас" төв эмнэлгийн захирал (Я.Энхчулуун)-д даалгасугай.

3. Эрт илрүүлэг үзлэгийг үр дүнтэй зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Халдварт бус өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн (Н.Мөнгөнцацралт)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн (Г.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

My doc. EMG-iin dargiin tushaal

Эрүүл мэндийн газрын даргын 2020
оны 6 сарын 15 өдрийн 4 дүгээр
тушаалын 1 дүгээр хавсралт

**ХҮН АМЫН НАС, ХҮЙС, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЭЛД СУУРИЛАН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГТ
ХАМРУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Үр дүн
Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр					
1	Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах төлөвлөлтийг Эрүүл мэндийн газрын даргаар батлуулж Медипас эмнэлэгт хүргүүлэх	6 сарын 10	ЭМГ	Медипас эмнэлэг	Урьдчилан сэргийлэх үзлэгийн нэгдсэн төлөвлөгөө батлагдаж хэрэгжүүлэгч байгууллагад хүрсэн байна.
2	Эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулах багийн, гишүүдийн ажил үүргийн хуваарийг баталгаажуулан Эрүүл мэндийн газарт ирүүлэх	6 сарын 15	Медипас эмнэлэг	ЭМГ	Ажил үүргийн давхардал үүсэхгүй илрүүлэг үзлэгийн хувь нэмэгдэнэ.
3	Хамрагдвал зохих хүн амын тоон судалгаа гаргах	6 сарын 10	ЭМГ	СӨЭМТ-үүд	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдвал зохих хүн амын судалгаа гарсан байна.
4	УСҮ-н дүгнэлтийг Health.gov.mn программд шивж сарын мэдээний хүснэгтийг дагуу үзлэгт хамрагдсан тоон мэдээг гарган, сар бүрийн 10-ны дотор мэдээг нэгтгэж Эрүүл мэндийн газарт ирүүлэх	Сар бүрийн 10-ны дотор	Медипас эмнэлэг	ЭМГ	Мэдээ тайлан цаг хугацаандаа нэгтгэгдэнэ.
5	Сар бүрийн шинээр илэрсэн өвчлөлийн мэдээллийг үндэслэн Хавсралт 4 дагуу холбогдох ЭМБ-	Сар бүрийн 15-ны дотор	ЭМГ	Медипас эмнэлэг	Шинээр илэрсэн өвчлөлийг ЭМБ-уудад мэдээлж, дараагийн шатанд

	уудад эргэн мэдээллээр ханган ажиллах				шилжихээс сэргийлнэ.
6	Урьдчилан сэргийлэх үзлэгийг холбогдох эмнэлзүйн стандарт, заавар, удирдамж, журмын дагуу зохион байгуулж үйлчлүүлэгчийг Коронавируст халдвараас сэргийлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллах	Жилийн турш	Медипас эмнэлэг	ЭМГ	Урьдчилан сэргийлэх үзлэг хууль дүрмийн дагуу хийгдэж үйлчлүүлэгчид эрсдэлгүй эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэнэ.
7	УСҮ-н урсгалын зураглал гаргаж, үйлчлүүлэгчид ойлгомжтойгоор ил тодоор байрлуулан, цахим бүртгэл дээр ирсэн үйлчлүүлэгчийг мэдээллээр хангах, утсаар цаг авах боломжийг бүрдүүлэх, хүн амын бөөгнөрөл үүсгэхээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Жилийн турш	Медипас эмнэлэг	ЭМГ	Үйлчлүүлэгч эмнэлгийн тусламж үйлчилгээг авах орчин, нөхцөл сайжирч мэдээлэл хүлээн авах боломжууд нэмэгдэнэ.
Сургалт сурталчилгаа, мэдээллийн чиглэлээр					
8	Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрсдэлийг бууруулах, амьдралын буруу хэв маягийг өөрчлөх зөвлөмж зөвлөгөөг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан үйлчлүүлэгч нэг бүрт ганцаарчилж өгөх	Жилийн турш	Медипас эмнэлэг	ЭМГ	Халдварт болон халдварт бус өвчний эрсдэлийг бууруулах, амьдралын буруу хэв маягийг өөрчлөх үйлчлүүлэгчийн тоо нэмэгдэнэ.
9	УСҮ-н ач холбогдол болон хожуу оношлогдсон өвчлөлийн хор уршиг, ЭМД-ын талаар иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох	Жилийн турш	Медипас эмнэлэг	ЭМГ	Урьдчилан сэргийлэх үзлэгийн талаар иргэдийн мэдлэг, мэдээлэл нэмэгдэнэ.

Эрүүл мэндийн газрын даргын 2020
оны 06 сарын 01 өдрийн 1/60
дүгээр тушаалын 2 дугаар хавсралт

**ХҮН АМЫН НАС, ХҮЙС, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЭЛД СУУРИЛАН УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГТ ХАМРАГДАХ ХҮН АМЫН ТОО**

Баг	18-34 нас	35-45 нас	46-64 нас	65-аас дээш нас
1-р баг, Зэст	1299	705	937	200
2-р баг, Оюут	1541	824	1062	137
3-р баг, Уурхайчин	1552	851	1225	187
4-р баг, Хүрэнбулаг	1433	829	1147	192
5-р баг, Уртбулаг	1357	780	912	153
6-р баг, Согоот	1411	815	1123	140
7-р баг, Дэнж	1726	827	1002	193
8-р баг, Бүрэнбүст	1169	696	715	117
9-р баг, Шанд	754	398	470	119
10-р баг, Наран	1205	543	794	179
11-р баг, Цагаанчулуут	1566	726	950	207
12-р баг, Булаг	973	486	711	157
13-р баг, Баянцагаан	1675	860	974	190
14-р баг, Говил	1068	491	754	154
	0	0	0	0
15-р баг, Рашаант	1390	753	897	211
17-р баг, Эрдэнэ	2134	1081	1083	257
18-р баг, Баянбулаг	1110	512	620	127
19-р баг, Их залуу	1300	645	736	182
20-р баг, Уртын гол	903	489	527	117
21-р баг, Даваат	1302	626	708	180
22-р баг, Яргуйт	1786	830	906	255
Баян-Өндөр сумын дүн	28654	14767	18253	3654
Жаргалант сумын дүн	1049	572	815	201
1-р баг, Улаантолгой	277	163	232	57
2-р баг, Жаргалант	351	179	274	77
3-р баг, Дулаан-Уул	421	230	309	67
Аймгийн дүн	29703	15339	19068	3855
Нийт		67965		

Эрүүл мэндийн газрын даргын 2020
оны 06 сарын 04 өдрийн 46 дүгээр
тушаалын 3 дугаар хавсралт

ХҮН АМЫГ НАС ХҮЙС, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЭЛД СУУРИЛАН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГИЙН САРЫН
ТООН МЭДЭЭ

Эрүүл мэндийн байгууллагын нэр:.....

2020 оны сарын өдөр

№	Насны бүлэг	Хүйс	Хамрагдсан хүний тоо	Бага эрсдэлтэй	Дунд эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй	Ганцаарчил сан зөвлөгөө өгссөн хүний тоо	Шинээр илэрсэн өвчлөлийн тоо	Диспансери йн хяналтад авсан хүний тоо	Эмчилж эрүүлжүүлсэн хүний тоо	Дээд шатлалын эмнэлэгт илгээсэн хүний тоо
1	18-34 нас	Эр									
		Эм									
2	35-45 нас	Эр									
		Эм									
3	46-64 нас багц 1	Эр									
		Эм									
4	46-64 нас багц 2	Эр									
		Эм									
5	65-аас дээш нас Багц 1	Эр									
		Эм									
6	65-аас дээш нас Багц 2	Эр									
		Эм									
7	Нийт	Эр									
		Эм									

Мэдээг хянасан:...../

/ албан тушаал

Мэдээг нэгтгэсэн:...../

/ албан тушаал

